



МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Бэлгэ тэмдэг батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 1.2, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Ёс зүйн хорооны бэлгэ тэмдэг”-ийг 1 дүгээр, “Бэлгэ тэмдгийн хэрэглээ”-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн хорооны Ажлын алба (Н.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.АМАРТӨГС



152501005

Ёс зүйн хорооны 2025 оны 03 дугаар
тогтоослын 1 дүгээр хавсралт

АТА11169 8448906
9023111371

ЁС ЗҮЙН ХОРООНЫ БЭЛГЭ ТЭМДЭГ

1. Ёс зүйн хорооны бие даасан, хараат бус байдлыг илэрхийлж, хамгаалах чиг үүргийг илэрхийлсэн бэлгэдэл /цаашид “бэлэг тэмдэг” гэх/ бэлгэ тэмдэгтэй байна.
2. Ёс зүйн хорооны бэлгэ тэмдэг нь дараах хэлбэр, өнгө, дүрслэлтэй байна.



- 2.1. Ёс зүйн хорооны бэлгэ тэмдэг нь дугуй /цагариг/ хэлбэртэй байх бөгөөд хоёр давхар цэнхэр өнгийн хүрээтэй байна.

2.2. Дугуй хүрээний дээд талд дугуй дотор Монгол улсын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан Соёмбо байх бөгөөд уламжлалт Монгол /үндэсний бичиг/ бичгээр баруун талд нь **Ёс зүйн** гэж, зүүн талд нь **Хороо** гэж, доод талд нь **ЁС ЗҮЙН ХОРОО** гэж крилл үсгээр цэнхэр өнгөөр бичсэн байна.

2.3. Гадаад харилцаа, ёспол хүндэтгэлийн арга хэмжээнд Бэлгэ тэмдгийн доод талд крилл үсгээр **ЁС ЗҮЙН ХОРОО** гэж бичсэн бичвэрийг **THE ETHICS COMMITTEE, MONGOLIA** гэж англиар бичиж болно.

2.4. Хүрээний дотор талд дөрвөлжин хэлбэрт байрших гар гараасаа барьсан хүмүүс мэт дүрс хөх, цэнхэр өнгөтэй байна.



Дөрвөн зүгт чиглэсэн үржих хэлбэртэй дүрс нь: Ёс зүйн хорооны үйл ажиллагаа нь дөрвөн зүг, найман зовхиист хязгааргүй, тасралтгүй явагддаг гэсэн санааг илэрхийлж аливаа юмс нэгдэж, нийлэх, хамтрах, бие биедээ татагдах, дэлгэрэх гэсэн утгыг илэрхийлнэ.

Дөрвөлжин хэлбэрт байрших хагас дугуй дөрвөн ширхэг холбоотой дүрс нь: Аюулгүй байдал бат, бөх, тогтвортой, найдвартай, гаднын нөлөөллөөс хамгаалагдсан, үнэт зүйлсийг баталсан илэрхийлэл юм.


Дөрвөлжин хэлбэрт байрших гар гараасаа барьсан хүмүүс мэт дүрс нь: Улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний гэсэн төрийн албыг илэрхийлэх бөгөөд хөх, цэнхэр өнгөөр харуулсан нь төрийн албан хаагч хүнлэг, энэрэнгүй, үнэнч шударга, хариуцлагатай, манлайлалтай, хамтаж

ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ, КОД

	C	M	Y	K	R	G	B
Хөх тэнгэр мэт өнө мөнхөд оршин тогтнохын бэлгэдэл	91	71	0	0	0	86	188
Үргэлж мөнх үнэнч шударга тогтвортой байдал	59	0	4	0	0	219	255
Оюун ухаан, сэтгэн бодох чадвар, авьяасын бэлгэдэл	1	15	100	0	255	211	0

- Цэнхэр - Үргэлж мөнх үнэнч шударга тогтвортой байдал
- Хөх - Хөх тэнгэр мэт өнө мөнхөд оршин тогтнохын бэлгэдэл
- Шар - Алтан Соёмбо, өндөр мэдлэгтэй оюун ухаан, сэтгэн бодох чадварын бэлэгдэл
- Цагаан – Цэвэр ариун байдлын бэлгэдэл

/ЯМАР Ч ЗҮЙЛ ДЭЭР ХЭВЛЭХЭД ЭНЭ ХАРЬЦАА АЛДАГДАХГҮЙ БАЙНА/



3. Ёс зүйн хороо нь: Туг, дарцаг, гишүүн нь бэлгэ тэмдэг агуулсан энгэрийн тэмдэгтэй байж болно.

4. Бэлгэ тэмдгийг Ёс зүйн хорооны гишүүд, алба хаагч бүр хүндэтгэн хамгаална.

-оо-

Ёс зүйн хорооны 2025 оны 03 дугаар
тогтоослын 2 дугаар хаворалт

ATA11169 8448906
9023111371

ЁС ЗҮЙН ХОРООНЫ БЭЛГЭ ТЭМДГИЙН ХЭРЭГЛЭЭ

1. Ёс зүйн хорооны бэлгэ тэмдэг /цаашид бэлгэ тэмдэг гэх/-ийг дараах байдлаар хэрэглэнэ.

2. Бэлгэ тэмдгийг зураглал, оёдол, хатгамал, хэвлэмэл хэлбэрээр дүрсэлж болно.

3. Бэлгэ тэмдгийг дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран баталсан эх загварын хэмжээ болон тодорхойлолтод заасан өнгийг чанд баримтална.

4. Ёс зүйн хорооны бэлгэ тэмдгийг дараах зүйлд хэрэглэж болно.

4.1. Туг, дарцаг, энгэрийн тэмдэг, бэлэг дурсгалын зүйл, албан хэрэгцээний бичиг хэргийн хэрэгсэл, урилга, үнэмлэх, нэрийн хуудас зэрэг эд зүйл дээр;

4.2. Ёс зүйн хорооны хэвлэмэл хуудас, албаны цахим орчин болон бусад баримт бичиг, алба хаагчийн үнэмлэх, нэрийн хуудсанд;

4.3. Ёс зүйн хорооны тээврийн хэрэгсэл, техник хэрэгсэлд;

4.4. Ёс зүйн хорооны албан болон түр байр, албан тасалгаа, хурлын танхимын хаяг;


4.5. Ёс зүйн хорооны үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээнд;

4.6. Гадаад харилцаа, ёспол хүндэтгэлийн арга хэмжээнд;

4.7. Тунийг Ёс зүйн хорооны Дарга, Ажлын албаны өрөөнд байршуулах бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд ирэх, албан хаагчид тангараг өргөх, тэмдэглэлт өдрүүдийн болон урлаг, спортын арга хэмжээнд;

5. Байгууллагын туг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран тэг, өргөн уртын 1:2-ын харьцааг чанд баримтална.


5.1. Тугын иш талаас 36 см, дээд доод талаасаа 20 см-ийн зайнд бэлгэ тэмдгийг байршуулна.



6. Энгэрийн тэмдэг нь: Ёс зүйн хорооны үйл ажиллагаа дөрвөн зүг, найман зовхист хязгааргүй, тасралтгүй явагдана гэсэн санааг агуулсан бат бэхийн бэлгэдэл /Нацагдорж/ хээний голд Ёс зүйн хорооны бэлгэ тэмдэгтэй, бэлгэ тэмдгийн оройн хэсэгт шигтгээтэй байна.

6.1. Нацагдорж хээ шаргал, бэлгэ тэмдэг мөнгөлөг өнгөтэй, соёмбын дээр шигтгээ байна.

6.2. Ёс зүйн хорооны гишүүд томилогдож чиг үүргээ хэрэгжүүлж эхлэх үед Ёс зүйн хорооны дарга хүндэтгэлтэйгээр тэмдгийг зүүж өгнө.



ГИШҮҮНИЙ ЭНГЭРИЙН ТЭМДГИЙН ХЭМЖЭЭ



7. Ёс зүйн хорооны бэлгэ тэмдгийг дуурайлган үйлдэх, хэлбэр, загвар, өнгө, хэмжээний харьцааг гүйвуулан өөрчлөх, дүрслэхийг хориглоно.

8. Ёс зүйн хорооны бэлгэ тэмдгийг энэхүү зүйлд зааснаас өөр үйл ажиллагаанд хэрэглэх тохиолдолд Ёс зүйн хорооны Хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

-оо-